



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/522

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/, 29.2 аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 01, 02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.БНХАУ-ын Ордос хот болон Эрээн хотод зохион байгуулагдах олон улсын Бизнес форумд оролцох, албан айлчлал хийх, үзэсгэлэн худалдаанд оролцох, хөдөө аж ахуйн чиглэлээр туршлага судлах арга хэмжээнд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 4134000 /Дөрвөн сая нэг зуун гучин дөрвөн мянган/ төгрөгийг Засаг даргын бусад зардлын “Дотоодын болон гадаад орнуудад зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн яармаг, бизнес форумд орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжин оролцуулах зардал”- аас, 6640000 /Зургаан сая зургаан зуун дөчин мянган/ төгрөгийг “Төсөл хөтөлбөрийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны зардал”-аас тус тус гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтийг ханган, дээрх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг аймгийн Засаг даргын орлогч /н.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 12-ний өдрийн
532 дугаар захирамжийн хавсралт



1. Эрээн хотын Орос, Монгол, Хятад гурван улсын үзэсгэлэн яармагт оролцох, Ордос хотод мал аж ахуй, хөдөө аж ахуйн чиглэлээр туршлага судлах үйл ажиллагааны зардлын тооцоолол

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Унааны зардал					
1	Эрдэнэт-Улаанбаатар	хүн	6	25,000	150,000
2	Улаанбаатар-Замын Үүд	хүн	6	61,000	366,000
3	Замын Үүд-Эрээн	хүн	6	18,000	108,000
4	Үзэсгэлэнд оролцх бизнес эрхлэгчдийн унааны зардал Эрденэт- Улаанбаатар	хүн	20	25,000	500,000
5	Үзэсгэлэнд оролцх бизнес эрхлэгчдийн унааны зардал/ Улаанбаатар-Замын үүд	хүн	20	61,000	1,220,000
6	Үзэсгэлэнд оролцох бизнес эрхлэгчдийн унааны зардал Замын үүд-Эрээн	хүн	20	18,000	360,000
7	Үзэсгэлэнгийн залны хаяг хэвлүүлэх 20ш буюу 60м2	м2	60	6,000	360,000
8	Эрээнд байрлах буудлын зардал	хүн	3	54,000	162,000
Хэсгийн дүн					3,226,000
Ордос хот явах унааны зардал					
1	Эрээн-Бугат	хүн	6	72,000	432,000
2	Бугат-Ордос	хүн	6	72,000	432,000
3	Ордос-Бугат	хүн	6	72,000	432,000
4	Бугат-Эрээн	хүн	6	72,000	432,000
5	Эрээн-Замын Үүд	хүн	6	18,000	108,000
6	Замын Үүд- Улаанбаатар	хүн	6	61,000	366,000
7	Улаанбаатар-Эрдэнэт	хүн	6	25,000	150,000
Хэсгийн дүн					2,352,000
Хоолны зардал					
1	Хоолны зардал /Ордос /	х/өдөр	6	108,000	648,000
2	Эрдэнэт-Улаанбаатар-Эрдэнэт, Замын үүд-Эрээн-Замын үүд хоолын зардал	х/өдөр	12	15,000	180,000
3	Эрээн-Бугат	х/өдөр	12	54,000	648,000
4	Ордос-Бугат	х/өдөр	12	54,000	648,000
Хэсгийн дүн					2,124,000
Зочид буудлын зардал					
1	Ордост байрлах /2 өдөр /	х/өдөр	6	108,000	648,000

2	Эрээнд буцаж ирэхэд хонох буудлын зардал	х/өдөр	6	54,000	324,000
Хэсгийн дүн					972,000
Бэлэг дурсгалын зардал					
1	Ордос, Эрээн хотын удирдлагад бэлэг дурсгалын зүйл	ш	2	250,000	500,000
2	Орон нутгийн үйлдвэрлэгчидийн бараа бүтээгдэхүүний дээж	ш	20	80,000	1,600,000
Хэсгийн дүн					2,100,000
Нийт дүн					10,774,000

00